# НИЙСЛЭЛИЙН 2021-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

*/2024 оны жилийн эцсийн байдлаар/*

2024 оны 06 дугаар сарын 31 Улаанбаатар хот

| № | Стратегийн зорилго, зорилт | Стратеги | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | | Хүрсэн түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилтийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | он | түвшин | |
| 3.1 | Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн зорилтот түвшинг бүрэн хангана. | Төсвийн үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх | Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ | Хувь | 2018 | 74.3 | 2024 | 100 | Нийслэлийн Өмчийн харилцааны газар нь нийслэлийн төсөвт 2021-2023 онд нийт 46,651.8 сая төгрөг төвлөрүүлж ажиллахаас 8,199.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж ажилласан байна. Үлдсэн дутуу төвлөрүүлсэн 38,452.0 сая төгрөг нь өмч хувьчлалын орлого бөгөөд 2021-2023 онуудад өмч хувьчлалын жагсаалтад орсон барилга байгууламжийг худалдан борлуулснаас орсон орлого 0 төгрөг байна. Үүнд:<br>-Түрээсийн орлого 6,077.4 сая төгрөг<br>-Өмч хувьчлалын орлого 186.1 сая төгрөг<br>-Ногдол ашгийн орлого 1,469.1 сая төгрөг<br>-Актлагдсан хөрөнгө борлуулсны орлого 467.1 сая төгрөг<br>2024 онд нийт 6,338,9 сая төгрөг төвлөрүүлэхээс 02 дугаар сарын гүйцэтгэлээр 212.8 сая төгрөг төвлөрүүлээд байна. |
| | | | Төсвийн нийт орлогын ДНБ эзлэх хувь | Хувь | 2018 | 5.8 | 2024 | 12.7 | |
| | | | Нийслэлийн нэгдсэн төсвийн нийт зарлагад татварын орлогын эзлэх хувь | Хувь | 2018 | 63.8 | 2024 | 69.4 | |
| 6.1 | Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий дэд төвүүдийг зорилтот | Төлөвлөлт, гүйцэтгэлийг уялдуулах | Өрхийн гол нэрийн бараа бүтээгдэхүүн худалдаж авах, үйлчилгээ авах дундаж зай | Км | 2021 | 5 | 2024 | 2.5 | НЗДҮАХХАХТ-ний төлөвлөгөөний 3.1 Нийслэлийн орлого, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж, сахилга батыг сайжруулна |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | түвшинд хүргэнэ. | | НЗДҮАХХАХТ-ний арга хэмжээний нийлбэр үзүүлэлт | Хувь | 2021 | 0 | 2024 | 100 | гэсэн зорилтын хүрээнд дараах 4 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>1. 3.1.1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн системд нийслэлийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, мэдээллээр баяжуулалт хийнэ.<br>- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ирсэн чиглэлийн дагуу нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн жилийн эцсийн санхүүгийн тайланг маягтын дагуу цахимаар шалган хүлээн авч баталгаажуулдаг. Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой 840 хуулийн этгээдийн 2022 оны санхүүгийн тайлангаар 5.3 их наяд төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Хэрэгжилт - 100%<br>2. 3.1.1.2.Нийслэлийн төсвөөс санхүүжиж буй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит хаалттай хувьцаат компани төрийн өмчит компанийн тоог бууруулна.<br>-2021-2023 оны хугацаанд НИТХ-ын шийдвэрээр Дүүжин тээврийн ашиглалтын өмнөх захиргаа ОНӨТҮГ болон Үртсэн шахмал түлшний үйлдвэр ОНӨААТҮГ-ыг татан буулгасан байна. НИТХ-ын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 67 дугаар тогтоолоор “Эмээлт аж үйлдвэрийн парк” ОНӨААТҮГ-ыг хаалттай хувьцаат компани болгон өөрчилж, компанийн хэлбэрт шилжүүлсэн.<br>Хэрэгжилт - 70%<br>3. 3.1.1.3.Нийслэлийн, төсөвт орон нутгийн өмчийн түрээсийн орлогоос төвлөрүүлнэ.<br>- 2021-2023 онд нийслэлийн төсөвт түрээсийн орлого 5,800.0 сая төгрөг |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | төвлөрүүлэхээс 6,405.9 сая төгрөг төвлөрүүлсэн байна.<br>Хэрэгжилт – 99%<br>3.1.1.5. Нийслэлийн өмчийн барилга байгууламжуудын зах зээлийн үнэлгээг тодорхойлно.<br>-Нийслэлийн өмчийн хөрөнгийн зах зээлийн бодит үнэлгээг тогтоож, өмч ашиглалтыг эргэлтэд оруулахаар Нийслэлийн өмчийн томоохон үл хөдлөх хөрөнгө болох 10 барилга, байгууламж, Хувьчлалын жагсаалтад орсон 15 барилга байгууламжийн зах зээлийн үнэлгээг 323.6 сая төгрөгөөр хийлгэсэн.<br>Хэрэгжилт 70%<br><br>Нийт 4 арга хэмжээний дундаж хувь 84,7%-тай байна. |